

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 6 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 6-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1130 болж, 2014 оны мөн үеэс 163 хүнээр, өмнөх сарынхаас 270 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 49.38 хувь буюу 558 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 642 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 289 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 45.33 хувь буюу 131 нь эмэгтэйчүүд байв.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 6 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 475 ажилгүй иргэний 26.95 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 19.58 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 17.26 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 9.05 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 5.47 хувь нь шилжин

суурьшсан; 2.95 хувь нь цэргээс халагдсан; 4.21 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 2.53 хувь нь байгууллага татан буугдсан; 2.11 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1.05 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 0.42 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.21 хувь нь хорих газраас суллагдсан; 0,21 хувь нь хөдөлмөрлөх насанд хүрч асрамжийн газраас гарсан; 8.0 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 15.13% нь дээд; 3.89% нь тусгай дунд; 10.0% нь мэргэжлийн анхан шатны; 52.92% нь бүрэн дунд; 13.89% нь бүрэн бус дунд боловсролтой; 2.65% нь бага; 1.50% нь боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



1.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 6 сард НДШ-ийн орлого 7.86 тэрбум ₮ болж төлөвлөгөө 93.93 хувь болж, төлөвлөгөөг 18 сум 25.05-0.77 хувиар давуулан биелүүлж, 9 сум 5.15-45.47 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 91.6 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 15.86-27.98 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 18.2 тэрбум ₮ зарцуулж, 100.0 хувь олгов. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 268120 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 41.22 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 30.13%; тэтгэмжийн даатгалын сангийн 97.54%; эрүүл мэндийн даатгалын сангийн 95.17%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 306.44%; ажилгүйдлийн даатгалын сангийн 79.42%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 6 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 49772 хүнд олгож, 5.6 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 52.8 хувь 55875 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 2.7 хувь 120.7 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 109320 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.9 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 24.9 хувийг халамжийн тэтгэвэр; 8.9 хувийг жирэмсэн болон нярай,

хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.5 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.1 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.5 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.9 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 6 сард 7670 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 13.1 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 6 сард 606 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 69 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 6 сард 1 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 6 гарч өмнөх оны мөн үеэс 1-ээр өссөн байна.

1-5 хүртлэх насандаа эндсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үед эндэгдэл гараагүй.


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



2015 оны эхний 6 сард нийт гарсан халдварт өвчнөөр 812 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 554 хүнээр өслөө. 2014 оны мөн үеэс цусан суулга 4.5 дахин, салхин цэцэг 2 дахин, бруцеллөз 1 дахин, тэмбүү 41.5, сүрьеэ 22.4 хувь, бусад 7.4 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 90 байгаа бол: Зуунмод 316, Баянжаргалан 140 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

- агаарын дундаж температур 14-20 градус дулаан буюу Өндөрширээт,

Залуучууд орчмоор дулаан, Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 30-35 градус буюу Өндөрширээт, Лүнд хамгийн их нь 35 градус, Дэлгэрхаан, Зуунмод орчмоор 30 градус дулаан.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 4 градус хүйтнээс 3 градус дулаан буюу Баянцагаан орчмоор 3 градус дулаан, Эрдэнэд -4 градус хүйтэн байв.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 1,4-35,9 мм, нутгийн баруун өмнөд хэсгээр буюу Дэлгэрхаанд 35,9 мм хамгийн бага нь Баянжаргаланд 1,4 мм тунадас оржээ.

-салхины их хурд 6-20 м/с, зарим газраар түр зуур 24-26 м/с хүрч, нөөлөг салхи ажиглагдлаа .

2015 оны 7 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 12-17, бусад нутгаар 17-22 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 12-17, бусад нутгаар 17-22 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй. Сэрүүсэх үе: Нэгдүгээр арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр сэрүүсч, уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 15-20 градус дулаан, голын сав газраар шөнөдөө 12-17 градус, өдөртөө 23-28 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө

9-14 градус, өдөртөө 19-24 градус дулаан байна. Халах үе: Ялангуяа хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагас, гуравдугаар арав хоногийн эхээр Туул, Сөгнөгөр голын сав нутгаар 30-35 градус хүрч халах төлөвтэй. Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 20-25 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 25-30 градус дулаан. Энэ сард орох тунадасны нийлбэр хэмжээ нь Заамар, Цээлийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим бороо орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үеэр нутгийн хойд хагаст, хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар түр зуурын бороо орно. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур ширүүснэ.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 6 сард аймгийн хэмжээнд 499 гэмт хэрэг бүртгэгдэж 463 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1.6 тэр бум ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар




Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 6 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 50.7 хувь нь хулгай, 23.6 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 7.6 хувь нь бусад хэрэг. 14.03 хувь нь замын осол, 2.8 хувь нь танхай дээрэм, 1 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Заамар, Батсүмбэр, Борнуур сумдад 10000 хүнд 316-125 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (55)-аас харьцангуй их байна. Зураг 1.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 31 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 28 эмэгтэй, 569 эрэгтэй нийт 597 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 60 хүнээр буурлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 6 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 589 гүйцэтгэх хуудсанд нийт 1.92 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 32 гүйцэтгэх хуудсанд ногдох 529.4 сая ₮-ийн материалд байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 557 гүйцэтгэх хуудасны 1.39 тэрбум ₮-өөс 214 хуудасны 422.2 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 38.42 хувь, үнийн дүнгээр 30.32 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 6.43 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 16.13 нэгжээр тус тус буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 6 сард кассын орлого 172.6 тэрбум ₮, кассын зарлага 169.9 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.5 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн багцын үлдэгдэл 2015 оны эхний 6 сарын байдлаар 124.1 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 5.9 тэрбум ₮-өөр буурлаа.

2015 он гарсаар нийт болон бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд

зээлдэгч нарт 66.2 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Харилцах дансны үлдэгдэл 6 сарын 30-ны байдлаар 259660 иргэний 12.3 тэрбум ₮ боллоо.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 6 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 5.4 тэрбум ₮, зарлага 31.8 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 116.79 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Газрын төлбөр, Ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, хүү торгуулийн орлого, төсөвт газрын өөрийн орлого, төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2014 оны мөн үеэс 7.2 хувь буюу 425.9 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 82.1 хувийг татварын, 16.2 хувийг татварын бус, 1.7 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 5.0 нэгжээр буурч, татварын бус орлого 3.83 нэгжээр өсч, хөрөнгө борлуулсны орлого 1.18 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 7.1 тэрбум ₮ болж аймгийнх 4.5 тэрбум ₮ буюу 64.29 хувь, сумынх 900.0 сая ₮ буюу 12.62 хувь, улсынх 1.6 тэрбум ₮ буюу 23.08 хувийг тус бүр бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлого 5.3 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 117.82 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 899.9 сая ₮ болж, төлөвлөгөө

153.22 хувь биелж, Батсүмбэр, Зуунмод, Сэргэлэн, Борнуур, Баянчандмань сумд 27.35-10.16 хувиар тасалдууллаа. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 4.5 тэрбум ₮ болж 111.59 хувь биелж Баянжаргалан, Цээл, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Баянцагаан, Эрдэнэ, Заамар, Архуст, Баянцогт сумд төлөвлөгөө 29.09-2.25 хувиар тасалдууллаа.




II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2015 оны 6 дугаар сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 57.84%, өмнөх оны мөн үеэс 8.10%-аар тус тус өсч, өмнөх сараас 0.05 хувиар буурав.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 6 дугаар сарын 0.05 хувийн бууралтад хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ голчлон нөлөөлөв. Хэдийгээр хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.16 нэгжээр буурсан ч хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0,08 нэгжээр өссөн.

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 6 сард пунктээр
Бүгд	-0.05
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.16
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.03
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.08
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00
05. ГЭР АХҮЙН ТАВИЛГА, ГЭР АХҮЙН БАРАА	-0.01
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.02
07. ТЭЭВЭР	0.00
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	-0.01
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00



II. Тариалалт

7 сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр 84296.5 гектар үр тариа, 4442.5 гектар төмс, 679.4 гектар хүнсний ногоо, 14760 гектар техникийн ургамал, 6663.3 гектар тэжээлийн ургамал, тариалсан нь 2014 оны мөн үеэс үр тариа 18214.5 гектар, тэжээлийн ургамал 2513.1 гектар, техникийн ургамал 773 гектараар тус бүр өсч, хүнсний ногоо 272.5 гектар, төмс 134.2 гектараар тус бүр буурлаа.



Төл бойжилт

7 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 87.0 хувь 1632.0 мянган хээлтэгч мал төллөж, 1640.3 мянган төл гарсны 96.9 хувь 1589.9 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 12.7 хувь буюу 208.2 мянгаар; бойжиж буй төл 10.6 хувь 169.3 мянгаар; 2006-2014 оны мөн үеүдийн дунджаас

төллөсөн хээлтэгч 34.4 хувь 561.3 мянгаар, бойжиж буй төл 64.7 хувь 561.6 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 52.6; гүүний 79.5; үнээний 80.7; эм хонины 88.4; эм ямааны 87.4 хувь нь тус бүр төллөв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	мян.тол				
	2011	2012	2013	2014	2015
Бүгд	1120.1	1159.8	1247.8	1420.7	1590.0
Ботго	0.4	0.5	0.5	0.5	0.5
Унага	44.4	49.9	55.3	68.8	80.2
Тугал	51.0	58.1	64.0	77.2	93.0
Хурга	600.7	615.0	677.7	763.8	867.3
Ишиг	423.5	436.3	450.3	510.4	548.8

Том малын зүй бус хорогдол


7 сарын 1-ний байдлаар оны эхний малын 1.0 хувь буюу 43745 том мал зүй бусаар хорогдсон нь 2014 оны мөн үеэс 3.5 дахин буюу 29885 толгойгоор өсч; 2006-2014 оны мөн үеүдийн дунджаас 1.9 дахин буюу 41352 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Эрдэнэсант, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Дэлгэрхаан сумд оны эхний малынхаа 2.9-1.8 хувь буюу 11276-801 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 46.9 хувь (бүгд 20527) болов.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр

	толгой				
	2011	2012	2013	2014	2015
Бүгд	27252	13714	30957	13860	43745
Тэмээ	3	5	23	12	18
Адуу	1516	1060	1683	1188	1916
Үхэр	1373	1318	1939	1309	2757
Хонь	9492	5685	13096	6019	20528
Ямаа	14868	5646	14216	5332	18526

Оны эхний тэмээний 0.6; адууны 0.6; үхрийн 0.9; хонины 0.9; ямааны 1.3 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар

хорогдсон малын 5.4 хувь нь өвчнөөр, 26.8 хувь нь хээлтэгч мал эзлэв.



II.5 Аж үйлдвэр

2015 оны эхний 6 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 8.04 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 2.1 дахин буюу 10.5 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Баянчандмань, Жаргалант, Зуунмод, Баянцагаан, Баянцогт, сумд 32.49-3.02 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 91.55) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2013 VI	2014 VI	2015 VI	2015 VI / 2014 VI %
Нийт дүн	3.02	4.89	15.44	315.7%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	0.47	1.35	12.43	920.7%
Боловсруулах аж үйлдвэр	1.27	2.55	2.03	79.6%
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1.27	0.99	0.98	99.0%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, нийтлэх хэвлэх дуу бичлэг хийх үйл ажиллагаа, ус ариутгал хангамжийн үйлдвэрлэл өмнөх оноос 8.2 дахинаас-5.9 хувь буюу 11.08 тэрбумаас -0.29 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 6 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 6.34, боловсруулах үйлдвэрлэл 13.13, ашигт малтмал олборлолт 80.53 хувийг тус тус эзлэв. Зураг II.7

Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга


Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 оны эхний 6 сард 1.92 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 17.77 хувь буюу 414.7 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 73.61 хувь нь инженерийн барилга байгууламжид; 19.23 хувь нь орон сууцны бус барилгад; 7.16 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2014 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 26.13; орон сууцны барилгын ажил 18.16 пунктээр тус тус буурч, инженерийн барилга байгууламжийн ажил 44.28 пунктээр өсөв.

Зураг II

Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар,

тэрбум төгрөгөөр



II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого эхний 6 сард 103.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 48.7 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.54 хувь буюу 37.2 сая ₮ өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 50.6 сая ₮ болж, нийт орлогын 78.64 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 21.35 хувийг албан бичгийн, 13.44 хувийг зорчигчдын, 65.21 хувийг бусад орлого эзлэв.



Улсын бүртгэлийн хэлтэс.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 6 сард нийт 5205 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 41.2 сая ₮-ийн орлого орууллаа.

Нийт орлогын 32.8 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 55.1 хувийг зээлийн барьцаанаас, 5.7 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 3.5 хувийг худалдааны үйлчилгээнээс, 1.9 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 6 сард нийт 932 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 45; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 0; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 212; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 5; бэлэглэлийн гэрээ 34; худалдах, худалдан авах гэрээ 46; өв залгамжлал 17; барьцааны гэрээ 253; бусад бүртгэл 320 тус бүр бүртгүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2015 оны эхний 6 сард нийт 14 аж ахуйн

нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 10; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 1; Хоршоо 2 үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 1; тус бүр бүртгүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2015 оны 6 сарын мэдээгээр 18 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 5; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 1; данс нэмэгдсэн, хасагдсан 2; удирдлага өөрчлөгдсөн 1; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 1; хаяг өөрчлөгдсөн 1; татан буугдсан 6; нэр өөрчлөгдсөн 1 тус бүр бүртгүллээ.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2015 оны эхний 6 сарын мэдээгээр нийт 150 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 271; үүнээс тохирлын гэрчилгээ 221, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 50; цулын хэмжүүр 576, үүнээс жин 453, туухай 122, автомашины жин 1; эзлэхүүний хэмжүүр 237, үүнээс түгээгүүрийн хошуу 177, сүмбэн метр 33, усны тоолуур 10; цахилгааны хэмжүүр 1315, үүнээс нэг фазын тоолуур 1185, гурван фазын тоолуур 130 тус бүр баталгаажуулсан байна.

Аудит

Аймгийн аудитын газар 2015 оны эхний 6 сард 185 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 148 нь зөрчилгүй, 35 нь хязгаарлалттай, 1 нь санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтүүдтэй гарлаа. Аудитын үйлчилгээний төлбөр 63.2 сая ₮ оруулахаас, орон нутгийн төсөвт 63.2 сая ₮-ийг орууллаа.

Тайлангийн хугацаанд 17362.0 сая ₮-ийн 117 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 69.4 сая ₮-ийг барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 0.05, үнийн дүнгээр 21.71 хувьтай гарлаа.